

**ТАМХИ ХУДАЛДААЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН СУНГАХАД
БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

1. Зөвшөөрөл хүссэн өргөдөл /ААНэгж тоот, иргэн гар өргөдөл/
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /иргэн бол цахим үнэмлэхний хуулбар/
3. Галын аюулгүй ажиллагааны дүгнэлт /ОБГ/
4. Тохирлын гэрчилгээ /СХЗ/
5. Татварын тодорхойлолт /ТХ/
6. ААН байгууллага нь ЕБС-ийн хичээлийн байр болон дотуур байрнаас 500 м зайд оршдог тухай зураглалыг гаргуулсан байх /ГХБХБГ/
7. Тэмдэгтийн хураамж төлсөн баримт-250 000 төгрөг /Татвараас код авч тушаах/

Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал		
№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
4.2	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох болон сунгах:	<p>Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг 2022.01.01-ээс 2023.04.21-ны байдлаар нийт 2 иргэнд олгосон. Үүний 1 нь шинээр, 1 нь сунгасан зөвшөөрөл. Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосон.</p> <p>Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгох, сунгах:</p> <p>Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг 2023.01.01-ээс 2023.04.21-ны байдлаар нийт 11 ААН болон иргэнд шинээр олгох болон сунгасан. Үүний 10 ААН-д шинээр олгож, 1 ААН, иргэний тусгай зөвшөөрлийг сунгасан. Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг ажлын 21 хоногийн дотор Сумын Засаг даргын Захирамжаар 1-2 жилийн хугацаатай олгосон. /ЕБ-ын 2, 3-р сургуулийн хичээлийн байр баригдаж сургалтын үйл ажиллагаа эхлэхтэй холбоотой 2 ААН-ийн зөвшөөрөл цуцлагдана/.2023 онд түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон Тусгай зөвшөөрөл байхгүй.</p>

**ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН СУНГАХАД
БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

1. Зөвшөөрөл хүссэн өргөдөл /ААНэгж, иргэн/
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /иргэн бол цахим үнэмлэхний хуулбар/
3. Галын аюулгүй ажиллагааны дүгнэлт /ОБГ/
4. Тохирлын гэрчилгээ /СХХ/
5. Татварын тодорхойлолт
6. Тэмдэгтийн хураамж төлсөн баримт-12500 төгрөг
/Татвараас код авч тушаах/

САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР